

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ДҮҮРГИЙН УДИРДЛАГУУД БОЛОН АЛБАН ТУШААЛТНУУДЫН ИРГЭДТЭЙ ХИЙСЭН УУЛЗАЛТЫН 2 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

2019 оны 06 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Засаг дарга болон дүүргийн удирдлагууд сард 2 удаа иргэд хүлээн авах уулзалтыг зохион байгуулж, уг уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна.

2019 оны 01 дүгээр сарын 01-нээс 2019 оны 06 дугаар сарын 25-ний өдрийг дуустал Засаг дарга нийт 52 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний санал хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой асуудлыг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.

Мөн судалж үзэн шийдвэрлэх шаардлагатай бичгээр хандсан өргөдөл, хүсэлтийг программд бүртгэж, хуулийн хугацаанд шийдвэрлэн иргэдэд холбогдох хариуг өгч ажиллалаа.



Уулзалтанд хамрагдсан иргэдийн асуудлыг хандалтаар нь авч үзвэл 16%-нь хөдөлмөр эрхлэлтийн тухай, 15%-нь мөнгөн тусламж болон эмчилгээний төлбөр хүссэн хүсэлтүүд эзэлж байна.

Иргэдэд тулгамдаж байгаа асуудлыг шийдвэрлэхийн зэрэгцээ тэднээс гаргасан шинэ санал санаачилгыг дэмжин ажиллаж дараах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

1. Сэтгэл зүйн зөвлөгөө facebook хаалттай групп, Баянгол дүүргийн иргэд болон хүүхэд залуучуудад зөвлөгөө өгөх нүүр номын хуудас нээн ажиллуулж байна. 2019 оны 2 дугаар улиралд биечлэн 15 айл, цахимаар 4000 орчим хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан.
2. Мөнгөн тусламж, дэмжлэг хүссэн 35 иргэнд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсэн.

3. Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, автозамын орц гарцыг хааж барьсан хашаа, барилга байгууламж болон түргэн үйлчилгээний цэгийг нүүлгэх гомдлын дагуу 26 зөрчлийг арилгасан.



Засаг дарга болон дүүргийн удирдлагуудын иргэдтэй хийсэн уулзалтын мэдээг сар бүр www.bgd.mn цахим хуудсаар мэдээлж ажилласан.

ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Х.МӨНХЗУЛ

ТАЙЛАН ГАРГАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ӨРГӨДӨЛ ГОМДОЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Д.ГЭРЭЛЭЭ